


“ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ” СЭТГҮҮЛД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛЭЭ НИЙТЛҮҮЛЭХИЙГ УРЬЖ БАЙНА



ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбар, Утга зохиол судлалын салбараас эрхлэн гаргадаг “Хэл зохиол судлал” сэтгүүл нь жилд 1 удаа хэвлэгддэг, олон улсын ISSN: 2308-510X дугаартай эрдэм шинжилгээний сэтгүүл юм. Манай сэтгүүл монгол хэл шинжлэл, утга зохиолын судлалд тодорхой хувь нэмэр оруулсан шинэлэг сэдэв, агуулга бүхий өргөн хүрээний судалгааг хамарсан монгол судлалын шилдэг өгүүллийг хүлээн авч нийтэлдэг, олон жилийн түүхтэй, Хэл зохиолын хүрээлэнгийн уламжлалт сэтгүүл билээ. Эрдэмтэн, судлаач та бүхнийг “Хэл зохиол судлал” сэтгүүлийн 2023 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэхийг урьж байна.

“Хэл зохиол судлал” сэтгүүлийн 48-р ботийн өгүүллийг 2023 оны 9 сарын 1 хүртэл borolzoid@mas.ac.mn цахим хаягаар хүлээн авна.

Өгүүлэл хүлээн авах: 2023.08.01 – 2023.09.01

Редакцын зөвлөл хянах: 2023.09.01 – 2023.10.01

Сэтгүүлд тэнцсэн эсэхийг зохиогчид мэдэгдэх: 2023.10.01-2023.10.15

Өгүүллийг засуулах: 2023.10.16 - 2023.10.31

Сэтгүүлийг хэвлэлд бэлтгэх, хэвлүүлэх: 2023.11.01- 2023.11.30

Өгүүллийг зохиогч өөрийн хийсэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн бичсэн байх бөгөөд өөр хэвлэлд нийтлээгүй шинэ өгүүлэл байх шаардлагатай. Та бүхэн манай сэтгүүлд нийтлүүлэх өгүүлэл дараах загвар, шаардлагыг чанд баримталж бичнэ үү.

Өгүүлэл тавигдах шаардлага

Өгүүллийн бүтэц:

- ХУРААНГУЙ (100-200 үгтэй, англи, монгол хэлээр бичсэн байх)
- ТҮЛХҮҮР ҮГ (англи, монгол хэлээр бичсэн байх)
- 1.УДИРТГАЛ
- 2.СУДАЛГААНЫ АРГА, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН
- 3.СУДАЛГААНЫ ХЭСЭГ (Гарчгийг бичсэн байх)
- 4.СУДАЛГААНЫ ҮР ДҮН (ХЭЛЭЛЦҮҮЛЭГ)
- 5.ДҮГНЭЛТ

- НОМ ЗҮЙ гэсэн үндсэн хэсгүүдтэй байна.
- ТАЛАРХАЛ (шаардлагатай бол)
- ХАВСРАЛТ (шаардлагатай бол)

Өгүүллийн хэлбэр:

Цаасны хэмжээ	A4
Хуудасны тоо	5-10
Цаасны хүрээ	Бүх талаас 25мм (дээд, доод, баруун, зүүн)
Фонт, хэлбэр	Times New Roman, үсгийн хэмжээ 12-pt
Мөр хоорондын зай	1.0 (space)
Гарчиг	Гарчиг болон судлаачийн мэдээллийг эхний хуудсанд бичнэ. Өгүүллийн нэрийг толгой үсгээр, тод хараар бичиж, дор нь баруун талд зохиогчийн овог нэр, улс, хот, ажил (сургууль, байгууллага)-ын нэрийг бичнэ.
Үндсэн болон дэдбүлэг гарчиг	Үндсэн бүлгүүдийн нэрийг хуудасны төвд толгой үсгээр бичнэ. Дэд бүлгийн гарчиг нь хуудасны зүүн талд байрлах бөгөөд том үсгээр эхлэн, жижиг үсгээр бичиж болно. Гарчгуудыг 1, 1.1, 1.1.1 гэх мэтээр дугаарлана.
Хүснэгт, зураг	Хүснэгт болон зураг нь нэгдмэл дараалсан дугаартай, агуулгаа тодорхойлсон нэртэй байх ёстой. Хүснэгтийн нэрийг дээр нь, зургийн нэрийг доор нь голлуулан бичнэ.
Зүүлт, тайлбар (footnote)	Үгийн тайлбар, засвар, залруулга, нэмж судлах материалуудын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгөх шаардлагатай бол хэрэглэж болно.

Эшлэлд дараах загварыг баримтална.

- Аливаа эх сурвалжаас ямар ч хэмжээний мэдээллийг шууд эш татсан, хураангуйлан бичсэн, өөрийн үгээр найруулан бичсэн зэрэг бүх тохиолдолд тухайн эх сурвалжийг бичвэр дотор эшлэх ба ном зүйн жагсаалтад оруулна.
- Wikipedia-аас эшлэл авахгүй.

1. Бичвэр дотор утга санаагаар эшлэхдээ: зохиогчийн нэрийн ард хаалтад тухайн бүтээлийн оныг бичнэ. Жишээ нь: Оросын эрдэмтэн З.К.Касьяненко (1964) монгол хэлний нэрлэхийн тийн ялгалыг “тодорхойгүй тийн ялгал” хэмээн нэрлэх нь илүү оновчтой гэж үзсэн байдаг.

2. Бичвэр дотор шууд эшлэхдээ:

Хувилбар 1: Хэрэв зохиогчийг өгүүлбэрийн эхэнд дурдан түүний бүтээлээс шууд эшилбэл, эшлэл (40-өөс доош үгтэй)-ийг хашилтад бичиж ард нь хаалтад он, хуудасны дугаарыг бичнэ. Жишээ нь: Монгол хэлний тийн ялгалын тухай ганц сэдэвт зохиол бичсэн Зоригт, Элсэнцэцэг нар “Эртний монгол хэлэнд нэрлэхийн тийн ялгал нь олон утга үйлдэлтэй байгаад, хэлний хөгжлийн явцад түүний зарим утга үйлдлийг бусад тийн ялгалаар илтгэн үзүүлдэг болсон” (2001:190) гэжээ.

Хувилбар 2: Хэрэв шууд эшлэл нь 40-өөс дээш үгтэй бол бичвэрийг хашилтад хийхгүйгээр догол мөрөөр авч налуу үсгээр бичиж, ард нь (Зохиогч, он: хуудас) гэж эх сурвалжийг бичнэ.

Жишээ нь:

Ертөнцийн бүх юм үзэгдэл эсрэг тэсрэг хоёр талын зөрчил тэмцлийн хүчээр орчин хөдөлж, хувьсан хөгжиж, бас тэдгээр хоёр талын нэгдлийн ачаар шүтэн барилдаж, оршин тогтнож байдаг түгээмэл зүй тогтолтой. Ертөнцөд эерэг сөрөг буюу арга билгийн талгүй ямар ч юм үзэгдэл байхгүй учраас тэдгээрийг судлахдаа бүрэлдүүлж байгаа элементүүдийн зөрчил тэмцэл, нэгдэл шүтэлцээг цогцоор нь анхаарч, “Ерөнхий тогтолцооны онол”-ын үүднээс тодорхойлох хандлага дэлхийн шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл болжээ. (Өнөрбаян, 2009: 35)

3. Олон зохиогчтой бүтээлээс эш татах:

Хувилбар 1: 2 зохиогчтой бүтээлээс эшилсэн бол эшлэх тохиолдол бүрт 2 зохиогчийн нэрийг хоёуланг дурдана. Жишээ: Хэл зүйч Зоригт, Элсэнцэцэг нар (2001) энэ тухайд...

Хувилбар 2: 3-5 зохиогчтой бүтээлээс эш татвал хамгийн эхний эшлэлийн тайлбарт бүх зохиогчийн нэрийг бичнэ. Дараа нь тэр бүтээлээс дахин эш татсан тохиолдолд зөвхөн эхний зохиогчийн нэрийг дурдаад, бусад зохиогчийн нэрийг бичилгүй “ба бусад,” (“и др.,” “et al.,”) гэж товчилоно. Жишээ нь: Бат-Ирээдүй ба бусад (2014) ...

Хувилбар 3: Ижил зохиогчтой бүтээлүүдийг Лувсанвандан (1967a: 125, 1967b: 258) хэлбэрээр эшлэх ба нэг доор олон бүтээлийг зэрэг эшлэх тохиолдолд (Санжеев, 1953: 250; Хасбаатар, 1982: 14; Базаррагчаа, 1997: 23) г.м-ээр он дарааллаар бичнэ.

4. Өөр хэлээр хэвлэгдсэн эх сурвалжаас эшлэл авахдаа:

Үндсэн бичвэрт агуулгыг монгол хэлээр эшилж, харин зохиогчийн нэрийг тухайн хэлээр нь бичнэ. Жишээ нь: Дүр-бүдүүвч нь ойлгох, ухаарах бидний туршлагыг холбон бүрэлдүүлдэг уураг тархины үйл ажиллагааны байнга давтагдах чанарын үлгэр мөн. (Johnson, 1987: 302) гэх мэт.

Ном зүйд дараах шаардлагыг баримтална. Үүнд:

- Эх сурвалжуудыг дугаарлахгүй.
- Ном зүй дэх эх сурвалжуудыг жагсаахдаа цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ. Хэрэв гадаад эх сурвалж ашигласан бол ном зүйг А.Монгол хэлээр, Б.Англи ба бусад хэлээр гэж ангилан бичнэ.
- Эшлэл аваагүй зохиогчийн нэрийг ном зүйд оруулахгүй. Өөрөөр хэлбэл, эшлэл, ном зүй тохирч байх ёстой.

Ном:

- 1 зохиогчтой бол:
Төмөртоого, Д. (2004). *Монгол хэл шинжлэлийн нэр томъёоны хураангуй толь*. Улаанбаатар: Адмон ХХК. [Tumurtogoo, D. *Mongol hel shinjleliin ner tomyoni huraangui toli* [A concise Dictionary of Linguistics]. Ulaanbaatar: Admon LLC. 2004.]
- 2 зохиогчтой бол:
Мөнх-Амгалан, Ю., Кан Шин. (2014). *Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Mönh-Amgalan, Yu., Kang Shin. *Orchin tsagyn mongol helnii бүтеевэр судлал* [The Morphology of Modern Mongolian]. Ulaanbaatar: Soyombo printing. 2014.]
- 3 ба түүнээс дээш зохиогчтой бол:
Бат-Ирээдүй, Ж., Буянтогтох, Г., Өнөрбаян, Ц., Пүрэв-Очир, Б., Пүрэвжанцан, А. (2014). *Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг*. Улаанбаатар: МУИС пресс хэвлэлийн газар. [Bat-Ireedüi, J., Buyantogtokh, G., Önörbayan, C., Pürev-Ochir, B., Pürevjantsan, A. *Mongol hel shinjleliin tailbar toli bichig* [Dictionary of Mongolian Linguistics]. Ulaanbaatar: MUIS press printing. 2014.]
- Эмхтгэгч бүхий эх сурвалжийг ном зүйд оруулахдаа эмхтгэгчийн овог, нэрийг дээрх

зарчмаар бичих ба ард нь таслалаар зааглан (эмх.) (ред.) (ed.) гэсэн үгийг нэмж оруулна.
Жишээ нь:

Цэрэнсодном, Д. (эмх.), (2021). Хэл шинжлэлийн үнэт дурсгалууд. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК. [Tserensodnom, D. *Hel шинjleliin unet dursгалууд* [Precious Monuments of Linguistics]. Ulaanbaatar: Mönhiin üseg printing. 2021.]

Өгүүлэл:

- 1 зохиогчтой бол: Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр, Сэтгүүлийн гаралтын дугаар* (тухайн оны дугаар), Хуудасны дугаар. Жишээ нь: Баярмаа, Б. (2022). 1960-1970-аад оны Монголын уран зохиолын шүүмж, судлалын зарим онцлог. *Хэл зохиол судлал*, XV(47): 301-319. [Bayarmaa, B. Some Features of Mongolian Literary Criticism and Research in the 1960-1970. *Hel zohiol судлал*, 2022, XV(47): 222-234.]
- 2 ба түүнээс дээш зохиогчтой бол: Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор., Хоёр дахь зохиогчийн нэр, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр, Сэтгүүлийн гаралтын дугаар* (тухайн оны дугаар), Хуудасны дугаар. Жишээ нь: Мөнхбаяр, Б., Тифани Канн. (2022). XX зууны монгол роман дахь шинэ эриний нээлт (“Тунгалаг Тамир”, “Үүрийн туяа”). *Хэл зохиол судлал*, 2022, XV(47): 268-291. [Munkhbayar, B., Turphaine Cann. Opening of a New Era in Mongolian novels of the 20th century. *Hel zohiol судлал*, 2022, XV(47): 268-291]
- Цахим сүлжээнээс авсан эх сурвалжийг ном зүйд оруулахдаа “Available at” эсвэл “Retrieved from” гэсэн үг бичнэ. “Available at” гэдэг нь судлаач тухайн эх сурвалжийг төлбөртэй авч ашигласан гэсэн санааг илтгэнэ. Энэ тохиолдолд эх сурвалжийн цахим хаягийг тодорхой тусгах шаардлагатай байдаг. Жишээ нь: Humbley, J. (2009). Accounting for term formation. *Terminology Science and Research* 20. Available at <http://lipas.uwasa.fi/hut/svenska/iitf/tsr2005/vol20/>. Accessed 15 June 2010.
- “Retrieved” гэдэг нь судлаач интернэтээс авсан эх сурвалжийг үнэ төлбөргүй авч ашигласан гэсэн санааг илтгэнэ. Жишээ нь: Lai.Gorman Yuan and Liberman (2008) Perception of Disfluency Language Differences and Listener Bias. *Interspeech*. pp. 2345-2348. <http://dx.doi.org/10.1.1.165.6866>. Retrieved from www.ling.upenn.edu/~kgorman/papers/laietal2007.pdf

Холбоо барих утас: Д.Боролзой 99018026, Г.Билгүүдэй 99005402

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбар, Утга зохиол судлалын салбар

2023.07.28